

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын
төсөл 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 02-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд,
Ц.Сандаг-Очир, Л.Оюун-Эрдэнэ;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Л.Мөнхбаатар, Г.Уянгахишиг,
Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Номтойбаяр.

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын
төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, О.Цогтгэрэл, Э.Одбаяр, Г.Уянгахишиг нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 55 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Одонгийн Цогтгэрэл нарын гишүүд ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 12 сарын 02-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хуралдаанд **“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тарааж өгсөн байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга, О.Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга, Э.Одбаяр Улсын Их Хурлын гишүүн, Г.Уянгахишиг Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулах болохыг Ажлын хэсэг Ж.Бат-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга гэсэн байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61,5 хувиар тогтоол батлагдлаа.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүний саналыг бас протоколд тусгая. Дэмжсэнээр тусгая.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

14.00 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ